

**ОРХОН АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ ХҮХРИЙН
ХҮЧЛИЙН ҮЙЛДВЭРИЙН ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

БАТЛАВ.

БАЙГАЛЬ ОРЧИН , АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН
УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА

Ц.УРАНЧИМЭГ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

“ХЭВИ ИНДАСТРИС ТЕХНОЛОЖИ ГРУПП”
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.ХИШИГЖАРГАЛ

**“ХҮХРИЙН ХҮЧЛИЙН ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

БАЙРШИЛ: ОРХОН АЙМАГ, БАЯН-ӨНДӨР СУМ

РЕГИСТРИЙН ДУГААР: 6610461

ХЯНАСАН:

БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН
УДИРДЛАГЫН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН..... /П.ШИНЭЦЭЦЭГ /

БОЛОВСРУУЛСАН:

“ХЭВИ ИНДАСТРИС ТЕХНОЛОЖИ ГРУПП” ХХК-ИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ АЖИЛТАН...../С.БУЯНХИШИГ/

2023 ОН

1.1 ГАРЧИГ

НЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	5
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл	5
1.2. Төслийн хүчин чадал	5
ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ	6
2.1. Агаарын чанар.....	6
2.2. Дуу шуугианыг бууруулах	8
2.3. Хөрсөн бүрхэвч.....	9
2.4. Усан орчин	13
2.5. Амьтны аймаг.....	15
2.6. Ургамлан нөмрөг.....	15
ГУРАВ. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	17
3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	17
3.2. Хог, хаягдлын менежментийн арга хэмжээ	20
3.3. Осол, эрсдэл, удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө	21
3.4. Тухайн жилийн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр.....	23
3.5. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	25
3.6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	26
3.7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал	27

2.1 ХҮСНЭГТИЙН ГАРЧИГ

Хүснэгт 1. Хяналтын төхөөрөмжийн төрөл, үр дүн.....	6
хүснэгт 2. Гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	9
Хүснэгт 4. Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	Error! Bookmark not defined.
Хүснэгт 5. Хог хаягдлын менежмент.....	20
Хүснэгт 6. Осол, эрсдэл, удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө	21
Хүснэгт 7. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	23
Хүснэгт 8. Удирдлага зохион байгуулалтын ажлын төлөвлөгөө.....	25
Хүснэгт 9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь.....	26
Хүснэгт 10. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний ажлын зардал.....	27

НЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр:	“Хүхрийн хүчлийн үйлдвэр”
Төсөл хэрэгжүүлэгч:	“Хеви индастрис технологи групп” ХХК
Регистрийн дугаар:	6610641
Улсын бүртгэлийн дугаар:	Түрээсийн газар
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, 44-14 тоот.

Төслийн байршил: Орхон аймаг, Баян-Өндөр сум, Баянцагаан багийн нутаг дэвсгэрт 1.0 га талбайг хамран байрлана.

1.2. Төслийн хүчин чадал

“Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр”-ээс гарах хүхрийг ашиглан жилд 12000 тн 98.5% агууламжтай хүхрийн хүчил (H₂SO₄) үйлдвэрлэнэ. Хүхрийн хүчлийн үйлдвэрийн цагийн хүчин чадал 1.5-2.0 т/ц байхаар байна. Үйлдвэрлэсэн хүхрийн хүчлийг “Эрдэнэт үйлдвэр”ТӨҮГ-ын “Үйлдвэр технологийн парк”-ийн Катодын зэс боловсруулах үйлдвэрт ашиглана.

Хүхрийн хэрэглээ: Цэвэр хүхэр-2021.053 тн

Нүүрс хэрэглээ: Үйлдвэрийн барилга байгууламжуудын халаалтад жилд нийт 29842.0 тн түүхий нүүрс ашиглана.

ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ

2.1. Агаарын чанар

Хүхэрлэг хий болон хүчлийн уурын ялгаруулалтыг бууруулах

Хүхрийн хүчлийн үйлдвэр ашиглалтад орсны дараа дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснээр төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, урьдчилан сэргийлэх боломжтой.

- Хүхэрлэг хийн нөлөөлөлд хайлуулах үйлдвэрийн ажилчид хамгийн ихээр өртөх ба ажилчдыг зориулалтын хувцас хэрэгсэл, маскаар хангах, хүхэрлэг хийн аюултай түвшнийг мэдээлэх мэдрэгч төхөөрөмжүүдийг ажлын байранд суурилуулах боломжтой бол ажилчин тус бүрийг мэдрэгч төхөөрөмжөөр хангаснаар ажилчдын эрүүл мэндийг хамгаалах боломжтой.
- Хүхэрлэг хий ялгаруулдаг янданд байнгын хэмжилттэй төхөөрөмжүүдийг суурилуулж, тогтмол хэмжилт хийх, жижиг яндангуудад тогтсон хөтөлбөрийн дагуу хэмжилт хийж ялгарлын хэмжээг тогтоож байх

Хүснэгт 1. Хяналтын төхөөрөмжийн төрөл, үр дүн

№	Хяналтын төхөөрөмжийн төрөл	Үр дүн
1	Хуурай скруббер	99% хүртэл (хийн нэгдлээс хамаарч); жишээлбэл, мөнгөн усны 50%; Хүхрийн давхар ислийн 95%
2	Нойтон скруббер	70-99% (тоног төхөөрөмж, загвар, хийн нэгдлээсхамаарч хийн хувьд) 99% (PM-ийн хувьд тоноглолын загвар, тоосонцрын хэмжээнээс хамаарна)
3	Агаар шүүгч-HEPA шүүлтүүр	99.97% (тоосонцрын хувьд -0.3 мкм диаметртэй)
4	Даавуун шүүлтүүр (уутны байшин)	99.99% (нарийн ширхэгт тоосонцор хүртэл)
5	Савны тоос цуглуулагч	99.99 +%
6	Циклон	90% (тоосонцрын $\geq 10-20$ мкм диаметртэй)
7	Цахилгаан тунадасжуулагч	99 +% (тоосонцорын хувьд -1.0 мкм диаметртэй)
8	Манан цуглуулагчид	99.9% (дуслын ≥ 0.3 мкм диаметртэй)
9	Шатаах зуух-Дулааны исэлдүүлэгчид	99.99% (VOC-ийн хувьд 99.99 +%)
10	Каталитик исэлдүүлэгч	99.99%
11	Каталитик реакторууд	90 +% (NOx-ийн хувьд) 99.99% (бусад хийн бохирдуулагчийн хувьд)
12	Био шүүлтүүр	98 +%

Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн угсралтын үед дээрх шүүлтүүрүүдээс тохирох хяналтын төхөөрөмжийг тавих нь зүйтэй юм.

- Үйлдвэрийн ажилчид хүчлийн уурын нөлөөлөлд хамгийн ихээр өртөх тул зориулалтын хувцас, хүчлийн уур шүүх зориулалт бүхий маскаар хангах, дотоод орчны агаарын чанарын мониторингийг тасралтгүй хийх, хүчлийн уур ихээр ялгардаг ажлын байруудад дохиолол бүхий мэдрэгч төхөөрөмжүүдийг суурилуулах, төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагааг хангаж ажилласнаар ажилчдын эрүүл мэндийг

хамгаалах боломжтой.

- Агаар бохирдуулах бодисуудын тархалтын зураглалд тулгуурлан орчны хяналт шинжилгээний цэгүүдийг тогтоон мониторингийн ажлыг хийх, зонхилох салхины доодчиглэлд автомат ажиллагаатай мониторингийн станц суурилуулж, ажиллуулах

Агаарын бохирдол хэмжих багаж:



Олон үйлдэл: гадна болон дотоод орчны агаарын найрлагад байгаа формальдегид, аммиак, ксилол, хорт хийнүүд, температур, чийглэгийг хэмжинэ.

Автомат хяналт: 0-99 минут хүртэл тасралтгүй ажиллах хугацааг хяналтын самбар дээр тохируулах боломжтой. Цагийн нарийвчлал болон дээжлэлтийн алдаа 0,1 секундээс хэтрэхгүй.

Температур болон чийглэгийн заалт: Орчны агаарын температур болон чийгшилтийг түүвэрлэн шинжилж болох ба хяналтын самбар дээрх шууд мэдээллийг харах боломжтой.

Агаарын урсгал: Энэ функц нь агаарын урсгалын тохиргоог хийх боломжтой болгосон. Хэвлэл: Агаарын температур, чийглэг, формальдегид, хугацааг хэвлэж гаргана.

Багажны үзүүлэлт:

1. Формальдегид (0.01 ~ 1.6 мг/м³)
2. Бензин (0.05 ~ 4 мг/м³)
3. Аммиак (0.05 ~ 3 мг/м³)
4. Толуол (0.05 ~ 4 мг/м³)
5. Ксилол (0.05 ~ 4 мг/м³) 6. TVOC (0.05 ~ 4 мг/м³)
6. Агаарын урсгалын хязгаар: 6*2.5 л / мин;
7. Нарийвчлал: ± 3% (уншилт хийх үед)
8. Агаарын урсгалын тогтвортой байдал: > 95%
9. Долгионы уртын тохиргоо: 500-900 (nm)
10. Хугацааны хяналт: 0-99 минут

Автомашин болон техник хэрэгслээс үүсэх хийн бохирдлыг бууруулах

Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах байгаа дизель түлшээр ажилладаг хүнд даацын тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмж, цахилгаан генераторууд нь хий төрлийн бохирдуулагчдын гол эх үүсвэр болно. Дизель хөдөлгүүрийн хаягдал утаанд янз бүрийн агаар бохирдуулагчид агуулагдах ба ялангуяа азотын ислүүд, хөө тортог(тоосонцор)-н ялгаруулалтын хэмжээ бусад бохирдуулагчидтай харьцуулахад нэлээд их байдаг. Иймд бохирдлын ялгаруулалтыг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай.

- Евро IV- с багагүй зэрэглэлийн түлш ашиглах
- Евро IV- с багагүй зэрэглэлийн хөдөлгүүр бүхий машин тоног төхөөрөмж ашиглах
- Хаягдал утааг цэвэршүүлэх DFU зэрэг фильтр ашиглах

Манай улсын гол түлш импортлогч ОХУ, БНХАУ зэрэг улсууд Евро V, VI зэрэглэлийн түлш үйлдвэрлэлд ерөнхийдөө шилжээд байгаа тул цаашид сайн чанарын түлш хэрэглэснээр бохирдлын ялгаруулалтыг бууруулах боломжтой.

Мөн сүүлийн үед үйлдвэрлэгдэж байгаа дизель хөдөлгүүрүүд нь мөн евро стандартад нийцсэн бохирдлыг бууруулах төхөөрөмжүүдээр тоноглогдсон байдаг тул уурхайн машин тоног төхөөрөмжийн сонголтод анхаарснаар төслийн хугацаанд үүсэж болох хий төлөвт бохирдуулагчдын хэмжээ болон түлшний шаталтаас үүдэлтэй тоосонцрын ялгарлыг бууруулах боломжтой. Шаардлагатай тохиолдолд утаа шүүгч фильтр ашиглаж болно.

Тоосжилт бууруулах

Тээвэрлэлтээс үүсэх тоосыг бууруулахад тоос дарагч буюу ихэвчлэн ус ашигладаг. Мөн түүнчлэн сурфактант уусмал, давс, нефтийн эмульс, нийлэг материал, цавуулаг материалуудыг ашигладаг. Хэдийгээр сайн чанарын материал ашиглан оновчтой шийдлээр барьсан зам нь хүнд даацын тээврийн хэрэгслүүдийн үүсгэх тоосыг бууруулахад ач холбогдолтой хэдий ч бусад аргуудыг мөн хэрэглэх шаардлагатай байдаг. Уурхайн талбайн нөхцөлөөс хамааруулж тоосжилт дарах уусмалыг сонгох ба уусмалуудын тоосжилтыг бууруулах үр ашгийг сайжруулсан гадаргуутай болон сайжруулаагүй гадаргуутай замаас үүсэх тоосны агууламжаас хамааруулж дараах томъёогоор тодорхойлдог.

$$CE = (1 - \frac{T}{U}) * 100$$

Энд: CE = Тоосжилтын бууруулах үр ашиг, %; U = сайжруулаагүй замаас үүсэх тоосны агууламж, мг/м³ ; T = сайжруулсан замаас үүсэх тоосны агууламж, мг/м³. Тоосжилтыг бууруулах уусмалын үр ашиг өндөр байна гэдэг нь замаас үүсэх тоос бага байна гэсэн үг. Энэхүү бууруулах үр ашиг нь нийт тоосны хувьд илэрхийлэгдэнэ.

2.2. Дуу шуугианыг бууруулах

Дуу шуугианы эх үүсвэр, тархалт нь төслийн үе шатууд болон тоног төхөөрөмжийн хүчин чадлаас хамаарах ба бууруулах арга хэмжээ нь үйл ажиллагааны онцлогоос хамаарна. ҮТП-ийн “Хүхрийн хүчлийн үйлдвэр” байгуулах төслийн хувьд үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжүүд, агааржуулалтын систем болон туузан дамжуургуудын цахилгаан мотор, илүүдэл уур гадагшлуулах хийн хаалтууд дуу чимээний гол эх үүсвэр болно.

Бүтээн байгуулалтын ажлын үед. Барилгын ажилд ашиглагдаж буй тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийг шаардлагагүй тохиолдолд хөдөлгүүрийг унтрааж хэвшсэнээр төслийн талбай болон ойр орчмын дуу чимээ, чичиргээг бууруулах боломжтой. Барилгын ажлын тоног төхөөрөмжийг дуу шуугиан, чичиргээ хамгийн бага тархах нөхцөлтэй газар сонгож байршуулах, дуу чимээ ихээр үүсэх ажлыг зөвхөн өдрийн цагаар хийх зэргээр бууруулах боломжтой.

Хүхрийн хүчлийн үйл ажиллагааны үед. Үйлдвэрүүдэд ашиглагдах тоног төхөөрөмжүүд болох бүх төрлийн цахилгаан моторууд, салхилуур болон шүүлтүүрийн сэнс, талбайд ажиллах бусад хөдөлгөөнт техник хэрэгслүүд нь дуу чимээ үүсгэгч эх үүсвэр болно. Эдгээр бүх үйл ажиллагаанаас үүсэх нэгдсэн шуугианы түвшинг бүрэн тодорхойлоход төвөгтэй байгаа ба станц ашиглалтад орсны дараа ажлын байрны хөдөлмөр аюулгүй ажиллагааны заавар, холбогдох стандартыг сайтар мөрдөж ажиллагсдыг шуугианаас хамгаалах хэрэгслээр хангах, үйлдвэрийн орчны бүс дэх шуугианы хяналт шинжилгээг хийн гадаад орчны стандарттай нийцэж байгаа эсэхийг тогтоон шаардлагатай тохиолдолд хаалт хашилт барих, дуу чимээ ихээр үүсгэгч зарим тоног төхөөрөмжүүдийг битүүмжлэх зэргээр шуугианы нөлөөллийг бууруулна.

Дуу чимээний нөлөөллөөс сэргийлэх:

- Тоног төхөөрөмжийн дуу чимээг бууруулахын тулд тусгаарлах, дуу намсгагч жийргэвч, шингээгч ашиглана.
- Чичирхийллийн судалгааны үед тэсэлгээний дуу чимээг багасгах /усан дэр хийх гэх мэт/
- Ажиллагсдыг ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэглэл (чихний бөглөвч)-ээр бүрэн хангаж, ашиглалтад хяналт тавьж ажиллах
- Тоног төхөөрөмжийн чимээ шуугианыг хүлцэх хэмжээнд тохируулна. Тоног төхөөрөмжүүдийн зэрэгцэн ажиллах хугацаанд хязгаарлалт хийх
- Ажилд хэрэглэх машин, тоног төхөөрөмжийг сонгохдоо Үндэсний болон Олон улсын дуу чимээний стандарт жишигт нийцэх үзүүлэлттэй эсэхийг сайтар судалж шалгах;
- Ажил гүйцэтгэх явцад тоног төхөөрөмжүүдийн чимээ шуугианыг хаах, багасгах үүрэгтэй эд анги хэвийн ажиллаж буй эсэхийг тогтмол шалгаж байх
- Машин механизм тоног төхөөрөмжид тогтмол засвар үйлчилгээ хийх, тэдгээрт дуу намсгагч нэмж хэрэглэх

2.3. Хөрсөн бүрхэвч

Төслөөс тухайн талбайн хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийн нийт үнэлгээ дунд зэрэг байх бөгөөд гол сөрөг нөлөөлөл нь карьерт өртөх талбайн хөрс их байх тул шимт хөрсийг хуулах, хадгалах стандарт MNS5916:2019, Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага MNS5917:2008, Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS5850:2019 зэрэг бусад хөрс хамгаалах хууль тогтоомжийг баримтлах шаардлагатай.



Хөрсний хамгийн гол онцлог шинж чанар нь үржил шимтэй байх явдал юм. Энэ шинж чанараараа газар, түүний хэвлийгээс тусгаар ойлголт болдог. Тиймээс хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах хамгийн гол зорилго нь тухайн хөрсөнд агуулагдах үржил шимт чанарыг бууруулахгүйгээр хадгалах, нөлөөлөлд өртөх хэмжээг бага байлгах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх чиглэнэ.

Хүснэгт 2. Гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

№	Үйл ажиллагаа	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ
---	---------------	--

1	Газар шорооны ажил хийх	<p>Шимт хөрсний хуулалт хийхдээ 20-30 см зузаантайгаар хуулж, зонхилох салхины чиглэл дагуу нуруулдан, овоолгын гадаргуугийн налууг 18 градусаар ихгүйгээр, хажуугийн налууг 25 градусаас ихгүй байхаар налуулан хэлбэршүүлнэ. /MNS 5917 : 2008/. Овоолгыг урьдчилан төлөвлөсөн талбайд байршуулна.</p> <p>Барилга байгууламж, бүтээн байгуулалтын ажлыг бүрэн гүйцэтгэж дууссаны дараа барилгын ажлын явцад элэгдэл, эвдрэлд орсон талбайг хэлбэршүүлж, ургамалжуулна. Энэ ажил нь хөрс хамгаалахаас гадна, агаарт тоос дэгдэх, тохижилтод эерэг нөлөө үзүүлдэг Газрын тухай хуулийн 50.1.1 заасны дагуу “Хөрсийг элэгдэх эвдрэх, хуурайших, намагжих, давсжих, бохирдох, хордохоос сэргийлэх арга хэмжээг өөрийн зардлаар хариуцан гүйцэтгэдэг байх. Үүний тулд барилга байгууламж барих үед эвдэрсэн хөрсийг нөхөн сэргээж, ургамалжуулах</p>
2	Машин механизмын хөдөлгөөн	<p>Үйл ажиллагааны бүсэд сайжруулсан замаар дотоод тээврийн ажлыг гүйцэтгэх бөгөөд олон салаа зам гаргахаас урьдчилан сэргийлж компанийн дотоод журамд тусгаж ажиллах шаардлагатай.</p> <p>Авто бааз, засварын газар орчмын талбайг хатуу хучилт хийж, тос тослох материал хөрсөнд асгарахаас урьдчилан сэргийлэх шаардлагатай. Сольсон болон бусад тос, тослох материалыг тусгайлсан цэгт, зориулалтын саванд цуглуулна.</p>
3	Тоног төхөөрөмжийн ажиллагаа	<p>Төслийн барилга байгууламжид ашиглаж буй тоног төхөөрөмжийн ажиллагааг хэвийн байлгах, эвдэрч гэмтэхээс сэргийлэх, зөөж тээвэрлэхдээ нэг замын бодлого баримтлах.</p>
4	Хог хаягдал, ариун цэврийн байгууламж байгуулах	<p>Ахуйн хатуу хог хаягдлыг тусгайлан бэлтгэсэн далан, хашаа хаалт бүхий тогтсон цэгт цуглуулах бөгөөд орон нутгийн захиргаатай хог хаягдлын гэрээ байгуулж, зохих төлбөрийг төлж ажиллах шаардлагатай. Шингэн хаягдлыг бетонон доторлогоотой, тунаах дамжлага бүхий сиптек танканд байршуулж тодорхой хугацаанд задлагч, ариутгагч бодисуудыг хэрэглэнэ.</p> 

		<p style="text-align: center;">ЭНГИЙН БИЕ ЗАСАХ ГАЗРЫГ “НҮХЭН ЖОРЛОН, УГААДАСНЫ НҮХ, ТЕХНИКИЙН ШААРДЛАГА” 5924: 2015 СТАНДАРТЫН ДАГУУ БАРЬЖ АШИГЛАНА.</p>  <p>НҮХЭН ЖОРЛОН Жорлон нь нүх, шад, бүхээг, хана, авч, агааржуулалтын хоолойн хэсгээс бүрдэнэ. Агааржуулалттай, үнэргүй, уламжлалт хэрэглээнд суурицсан. Өтгөнийг дүүрсэн үед суллах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагад хандаж соруулж зайлуулна.</p> <p>БОРДООЖУУЛАХ Бордоожуулах жорлон нь нүх, сүүр, бүхээг гэсэн үндсэн хийцтэй бөгөөд ялгадасыг тусгаарлаж, шингэн нь нүхэнд шингэж, өтгөн нь сабанд хуримтлагдана. Өтгөнийг дүүрсэн үед суллах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагад хандаж соруулж зайлуулна.</p> <p>БАГА УСААР ЗАЙЛУУЛАХ Бага хэмжээний усаар зайлуулах жорлон нь нүх, бүхээг гэсэн үндсэн хийцтэй. Ялгадасыг усны урсгалаар нүхэнд хөөж зарчимд тулгуурлана. Нүх дүүрсэн үед бохирьг соруулан зонх журмын дагуу зайлуулна. Нэг удаа 2-3л ус зарцуулах тус усны хэрэглээ бага.</p> <p>ХУУРАЙШУУЛАХ Хуурайшуулах жорлон нь ялгадасыг хатааж зарчимд тулгуурладаг бөгөөд нүх, сүүр, бүхээг гэсэн үндсэн хийцтэй. Эзэлжлэн ашиглах 2 сүүртэй тэт дахин өөр жорлон барих шаардлагагүй. Өтгөнийг дүүрсэн үед суллах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагад хандаж соруулж зайлуулна.</p> <p>Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу тогтоосон цэгээс бусад газарт хөрсийг хог хаягдлаар бохирдуулахгүй байх, эрүүл ахуйн шаардлага хангасан бохир ус зайлуулах байгууламжтай байх, барилгын ажлын явцад болон дууссаны дараа эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, тогтоосон авто зогсоол болон зорчих хэсгээс бусад газарт тээврийн хэрэгсэл зогсоох болон зорчихыг хориглох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлснээр хөрсний элэгдэл, эвдрэл, бохирдлыг бууруулах боломжтой.</p>
<p>5</p>	<p>Түүхий эд бэлтгэх хэсгээс тээвэрлэх (ачааны машинаар)</p>	<p>Технологийн тээвэрлэлт хийх төв замыг хусалт хийж, замын өргөсөлтөөс сэргийлсэн хайс хийх, тээврийн хэрэгслийг бороо, цасны улиралд шаварт суулгахгүй байх арга хэмжээ авах, шаардлагатай хэсгүүдэд хөрсийг дагтаршуулж, зам талбайг засах, засвар арчлалтын ажлыг тогтмол хийж байх. Тээврийн машины явах давтамж нэмэгдсэн тохиолдолд холбогдох хууль журам, мэргэжлийн байгууллагын шаардлагын хүрээнд авто замын чанарыг сайжруулах шаардлагатай.</p>
<p>6</p>	<p>Шимт хөрсний овоолго үүсгэх</p>	<p>Шимт хөрсний хуулалт хийхдээ 20-30 см зузаантайгаар хуулж, зонхилох салхины чиглэл дагуу нуруулдан, овоолгын гадаргуугийн налууг 18 градусаар ихгүйгээр, хажуугийн налууг 25 градусаас ихгүй байхаар налуулан хэлбэршүүлэн хадгална.</p>

		
		
<p>7 Химийн бодис ашиглалт, хадгалалт, тээвэрлэлт</p>		<p>Химийн хортой болон аюултай бодисыг зориулалтын агуулахад хор аюулын лавлахын мэдээлэлд заасан нөхцөлд хадгалах, ашиглалт зарцуулалтад тогтмол хяналт тавьж бүртгэж байх</p> <p>Агуулахыг галд тэсвэршилтийн зэргийг хангахуйц материалаар, болзошгүй ослын үед хөрсөнд болон гадагш бодис алдагдахааргүй шалтай (цемент, плита г.м), бат бэх хамгаалалт бүхий цонх, хаалга, үерийн хамгаалалтын далан, сувагтайгаар байгуулах;</p> <p>Химийн бодис хадгалах агуулах орчмын талбайг 2 метрээс багагүй зайд хатуу хучилт хийх</p> <p>Гадна болон дотоод орчны гэрэлтүүлгийг стандартын дагуу хийх, хөрсөнд алдагдахаас сэргийлж битүүмжлэл бүхий саванд хадгалах.</p> <p>Хоорондоо үл нийцэх химийн бодисуудыг нэг дор хадгалахгүй байх</p>

	<p>Ашиглаж байх хугацаандаа хөрсөнд алдахаас сэргийлж тухайн орчныг хамгаалалтын хальс болон үл нэвчих материал дэвсэж нэвчихээс хамгаалах</p> <p>Хүхрийн хүчил хөрсөнд өлдөгдөж буй эсэхийг хянах зорилгоор “хөрсний хяналтын цэг” байгуулах</p> <p>Хөрсний хяналтын цэгээс дээж авахдаа 3 м хүртэлх гүн ухаж үе давхарга бүрээс жилд 1 удаа дээж авч бохирдлыг тодорхойлж байх</p> <p>Хүхрийн хүчлийг тээвэрлэхдээ битүүмжлэл сайтай, ус нэвтрэхгүй саванд хагарч гэмтэхгүй сав баглаа боодолтойгоор тэсрэх болон, галын аюултай, амархан исэлдэх бодистой хамт биш, тусгай тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. Ямар нэгэн байдлаар алдагдсан тохиолдолд 60%-ийн кальцжуулсан сод, 30%-ийн шингэн шил, 10%-ийн сульфанолын уусмалаар саармагжуулж, хүчлийн үлдэгдэл байхгүйг шалгасны дараа химийн бодисыг аюулгүйгээр зайлуулах зохих зөвлөмж, зааврын дагуу устгах эсвэл зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж байгууллагад хүлээлгэн өгнө.</p> <p>Мөн содын ба шохойн уусмалаар саармагжуулж дараа нь хуурай элс болон шороонд шингээн авч химийн хаягдал бодисын саванд хадгалах шаардлагатай./шатах материал ашиглаж болохгүй.</p>
--	---

2.4. Усан орчин

Газрын доорх ус

Хүхрийн хүчлийн үйлдвэр барьж байгуулах болон ашиглах явцад газрын доорх усанд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна. Үүнд:

- Усны менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх ба сонирхогч бүх байгууллага болон объектуудын ус ашиглалтын нөхцөлийг тохиролцох
- Усан хангамжийн эх үүсгэвэр, дамжуулах шугам хоолой болон үйлдвэрийн объектуудыг тойруулан ариун цэвэр, эрүүл ахуйн бүсийг тогтоох
- Гүний худгууд дээр усны түвшин хэмжигч автоматудыг суурилуулж, мэдээллийг тогтмол бүртгэж байх шаардлагатай байна. Мониторингийн хяналт явуулахад лэвэлогэр (levelogger-LTF300/M100, Model3001) болон барологгэр (Barologger LTF5/M15, Model 3001) загварын түвшин хэмжигч автоматудыг ашиглах боломжтой юм.
- Газрын доорх усны үйлдвэрлэлийн зэргээрээ тогтоогдсон нөөцөөс илүү усыг авч хэрэглэх, гүний усны даралт түрэлтээс хамаарсан усны түвшний зөвшөөрөгдөх доошлолтыг норм дүрэмд заасан хэмжээнээс хэтрүүлэхийг хориглоно. Үүнд даралттай усны хувьд цооногт “тогтсон түвшин”-ий зузааны 75%-иас ихгүй, даралтгүй усанд 50%-иас ихгүй байхаар тооцно.
- Үйлдвэрлэлийн усан хангамжид ашиглах эргэлтийн усны хэмжээг нэмэгдүүлэх замаар газрын доорх түүхий усны хэрэглээг бууруулах. Цэвэрлэсэн хур тунадасны усыг гал унтраах ба үйлдвэрийн орчны ногоон байгууламжийг услахад ашиглах
- Ундны усны чанар хангахуйц усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахгүй байх.
- Унд-ахуйн хэрэглээний ба гал унтраах зориулалтын усны дамжуулах хоолойн сүлжээ, унд-ахуйн болон үйлдвэрлэл, хур тунадасны усыг ариутгах татуургын сүлжээг тусдаа байхаар төлөвлөх

- Үйлдвэрийн хашаан доторх талбайг хатуу хучилттай болгох, тоног төхөөрөмж байрлуулсан хэсэгт бүхээг, саравч хийх, хаягдал усыг цуглуулах ба татан зайлуулах боломжийг бүрдүүлэх
- Бүх төрлийн хаягдал усыг стандартын шаардлагын хэмжээнд хүртэл цэвэршүүлэх, бохирдуулагч бодис хөрс болон хөрсний усанд орохоос сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Үйлдвэрийн талбайд аливаа үйл ажиллагаа явуулахын өмнө үйлдвэрлэлийн болон ахуйн бохир ус, элдэв хог хаягдал сайр, судгийн голдиролд хаягдаж бохирдол бий болгохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх шаардлагатай.
- Түр урсцын үргэлжлэх хугацаа, хэмжээ, горим нь тухайн жил, улирлын цаг агаарын байдал, хур тунадасны хэмжээнээс хамаарч янз бүр байдаг. Их хэмжээний цас орж хайлах, үргэлжилсэн бороотой үед сайруудаар ширүүн урсгалтай үер буух магадлал өндөр байна. Иймд үерийн уснаас хамгаалах барилга байгууламжийн зураг төслийг үйлдвэрийн ерөнхий төлөвлөлт, байгаль цаг уурын нөхцөл, үерийн усны эрчимжил, инженерийн тооцоолол судалгаанд тулгуурлан усны мэргэжлийн байгууллагаар хийлгэж барьж байгуулах шаардлагатай.
- Газрын доорх усны нөөц ба чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахын тулд Монгол улсын Усны тухай хуулийн заалтуудад нийцүүлэн дор дурдсан арга хэмжээг авч ажиллах шаардлагатай. Үүнд:
- Ус ашиглах дүгнэлтийг холбогдох байгууллагаар жил бүр гаргуулах.
- Ахуйн хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл авах, үйлдвэрлэлийн явцад гарах бохир усыг хаягдал усны стандартын шаардлагад нийцүүлэн цэвэрлэж, ашиглах буюу гадагшлуулах
- Худаг, цооног бүрийг тоолууржуулах
- Усан сан бүхий газарт цацраг идэвхт болон химийн хорт бодис, халдвар үүсгэгч, хог хаягдал, бохир ус хаях, хадгалах, машин техник, бохир зүйлс угаахыг хориглоно.

Гадаргын ус

Төсөл хэрэгжих талбайд хийгдсэн судалгаа, тооцооны үр дүнд үндэслэн дараах дүгнэлтэд хүрч байна. Үүнд:

- Аливаа үйл ажиллагаа явуулахдаа үйлдвэрлэлийн болон ахуйн бохирдол гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөж байвал зохино. Хур тунадасны ус, ялангуяа хүчтэй аадар борооны ус нь үйлдвэрлэлийн болон ахуйн бохир ус, элдэв хогхаягдлыг сайр, судгийн голдирол руу урсган бохирдол бий болгохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах шаардлагатай.
- Иймд үйлдвэрийн объектууд, засвар үйлчилгээний газар, шатахуун түгээгүүрийн станц, авто зогсоол болон хатуу хог хаягдал хадгалах цэг болон бохирдол тархаж болзошгүй бусад байгууламжийн талбайг хатуу хучилттай болгож бохирдол тархахгүй байх, цуглуулах ба татан зайлуулах боломжийг бүрдүүлбэл зохино.
- Үйлдвэрлэлийн ба ахуйн хаягдал усаар гадаргын болон газрын доорх усны нөөцийг бохирдуулахгүй байх арга хэмжээг авч ажиллах, хог хаягдлын цэгийг шаардлагын дагуу байгуулах
- Үйлдвэрийн талбай руу чиглэсэн сайр, жалгын дагуу урсах үерийн усны хамгийн их өнгөрөлтийг тооцсон үерээс хамгаалах далан шуудууны зураг төсөл гаргах, бариулахажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх нь зүйтэй. Энэ байгууламжид усны угаагдал, голдирлын эвдрэл зэргээс хамгаалах арга хэмжээг тусгасан байх шаардлагатай.
- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-тай ус гэрээ (Усны тухай хууль болон Ус бохирдуулсны

төлбөрийн тухай хууль) байгуулж ажиллах нь зүйтэй юм.

- Үйлдвэрийн хэрэгцээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ -аас авч буй шугам хоолой, худагт тоолуур тавих хэрэгтэй.

2.5. Амьтны аймаг

- Газар шорооны ажил гол төлөв газар гэсэх үе болох 4 сарын 1-нээс эхэлдэг ба энэ үе нь амьтан ичээнээс гарч идэвхтэй амьдарч эхлэх үетэй тохирдог. Хөрс тэгшлэх ажил тус талбайд амьдрах жижиг мэрэгч амьтдын үржлийн үетэй давхцаж болзошгүй тул 4-р сараас өмнө хөрс хуулалт, гадаргыг тэгшлэх ажлыг багтаан хийвэл олонх амьтан 5-6-р сард төллөдөг ба тэдгээр амьтад төллөхөөс өмнө амжих тул амьтны хорогдлын тоо бага байх болно.
- Түүнчлэн барилга байгууламжийн цонхонд шавж орохоос хамгаалсан жижиг нүхтэй тор хийх шаардлагатай.
- Барилга байгууламж дээр, хөрсөн дээр шинээр суурьших шувууны ангаахай дэгдээхэйн бойжилт 8-р сарын сүүлчээр дуусдаг тул хөрс овоолгыг буцааж түрэх ажлыг үүрээ засаж, ангаахай дэгдээхэйгээ бойжуулдаг шувууны үр төлийг бие гүйцсэн үеэс хойш буюу 9-р сарын эхнээс хийхэд анхаарах хэрэгтэй.
- Үйлдвэрээс ялгарах хийн бодис мал, амьтны эрүүл мэндэд сөрөг нөлөө учруулж болзошгүй тул хяналт тавих шаардлагатай.
- Бидний олон жилийн ажиглалтаар хогийн цэгт үнэг, хярс, хүнд ойромсог шувууд ирж хооллодог болох нь ажиглагдсан тул хогийн цэгийг ариун цэврийн журмын дагуу байгуулж, амьтан муудсан хоол идэх, өвчлөхөөс сэргийлэх нь чухал.
- Үйл ажиллагааны үед үүссэн илүүдэл нүх, цооног, овоолсон шороо зэргийг тухай бүрт нь булж хуучин байдалд нь оруулан, техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг цаг хугацаанд нь чанартай хийж зохих шатны хяналтын байгууллагад байх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх.
- Амьтдын идэш тэжээл эрж хайх, нүүдэллэх зам харгуй, нүх оромжийг анхааруулсан тэмдгүүд байрлуулах, эрүүл хөрс газраар тээврийн хэрэгсэл хүнд машин механизмаар явахыг хориглох;
- Төслийн талбайн ойр ормын ан амьтадын тоо толгойн өөрчлөлтийг хянаж, ажиглалт явуулж байх. Ингэснээр төслийн талбай болон түний ойр орчмын амьтдыг таньж мэдэх, тэдгээрийг хамгаалах арга хэмжээ авахад дөхөмтэй байх бөгөөд өвөлжилт хүндэрсэн үед малчдад өвс тэжээлийн тусламж үзүүлэх, зэрлэг ан амьтад өвс, тэжээл, хужир, мөс тавьж өгөх зэрэг орчны ан амьтдыг хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Шувууны аюулаас урьдчилан сэргийлэхэд хяналт болон үргээх ажиллагааг сайтар зохион байгуулах нь чухал.
- Хортой бодис асгарах, гоожих тохиолдолд орчны хөрс, ус, ургамал, амьтан хөнөөгдөх аюултайг байнга анхаарч хяналт үзлэг үйлчилгээг тогтмол хийж байх;

2.6. Ургамлан нөмрөг

- Хөрс хуулалт хийсэн талбайн хэжээтэй тэнцэх хэмжээний талбайд мод зүлэг тарих
- Нөлөөллийн бүсийн талбайд ургаж байгаа ургамлын төрөл зүйлийн судалгаа хийж, зүйлийн бүрдлийг тогтоож байх
- Талбайд ургамжилтын мониторингийн цэг байгуулж, жил бүр хяналт тавих, өөрчлөлт гарвал зохих зөвлөмжийн дагуу арга хэмжээ авах
- Нөлөөллийн бүсэд байгаа ургамлаас хүнд элементийн судалгаа хийх, бохирдол илэрвэл мэргэжлийн байгууллагад хандах

- Ургамлын анатоми, морфологи физиологийн судалгааг мэргэжлийн хүмүүсээр хийлгүүлж, хамтран ажиллах
- Тоосжилтыг дарах, агаарт ялгарах тоосжилтыг бууруулахын тулд усалгааг тогтмол хийж байх
- Ногоон байгууламж байгуулах, дизайн, интерьер шийдэлтэйгээр хийх шаардлагатай мэргэжлийн байгууллагын зөвлөгөө авахаас гадна мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.

ГУРАВ. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулахарилгах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо, хэмжээ, Хэмжих нэгж	Нэгжийн зардал мян.төг	Хэрэгжүүлэххугацаа, Давтамж	Баримлах эрзүйнбаримт бичиг
Агаарын чанар						
Хүхрийн хүчлийн үйлдвэр, Дулааны цахилгаан станцаас хаягдах агаар бохирдуулагчид болон хаягдал үнс хүрээлэн буй орчны агаарын чанарт нөлөөлөх	Утаа шүүх системийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээг тогтмол хийх	Бүс нутаг	-	1000.00	Сар бүр	“Агаарын тухай”хууль MNS4585:2016 Агаарын чанар.Техникийн ерөнхий шаардлага.
	Утааны хийн хэмжилтийн төхөөрөмжүүд суурилуулахтэдгээрийн хэвийн ажиллагааг хангах	Бүс нутаг	-	Хөрөнгө оруулалтын зардалд тусгах		
	Хаягдал үнс булшлах талбайг тохижуулах, үнс тээвэрлэлтийн технологи горимыг мөрдөж ажиллах	Төслийн талбай	-	Барилга, байгууламж барих ажлын төлөвлөгөөнд тусгасан		
	Ус цацах тоног төхөөрөмж авах	Төслийн талбай	-	Үйл ажиллагааны зардалд тусгасан		
	Хөдөлмөр хамгааллын хэрэгслийн ашиглалтад хяналттавих	Ажилчдад	-	1 000.0	Сар бүр	

**Орхон аймаг, Баян-Өндөр сум, Баянцагаан багийн нутаг дэвсгэрт орших “Хеви
индастрис техноложигroup” ХХК-ийн “Хүхрийн хүчлийн үйлдвэр” төслийн байгаль
орчны менежментийн төлөвлөгөө**

2023 он

Барилгын материал, тоног төхөөрөмж тээвэрлэхэд ашиглагдаж буй хүнд даацын тээврийн хэрэгслээс ялгарах хорт бодис бүхий хий, тоос шороо	Автомашинуудад засвар үйлчилгээг цаг тогтмол хийж, чанартай түлш шатахуун ашиглах, хорт утааны хэмжээг стандартад заасан зохих зөвшөөрөгдөх хэмжээнд нь барих, зориулалтын утааны шүүлтүүр суулгах	Авто машин бүрд	-	1 000.0	1 сард	(MNS) 4585:2016, MNS 3384:82, MNS 3383:1982 Агаар мандал. Бохирдлын эх үүсвэр, нэр томъёо, тодорхойлолт
Зардал					3 000.0	
Хөрсөн бүрхэвч						
Газар шорооны ажил хийх явцад хөрсөнд эвдрэл үүсэх	Барилга байгууламж барих болон газар эвдэх бусад үйл ажиллагаануудыг эхлүүлэхээс өмнө өнгөн хөрсийг хуулан авах. Хуулан авсан өнгөн хөрсийг тусгайлан зассан овоолго байдлаар хадгалах	Төслийн талбайд	-	Барилга, байгууламж барих ажлын төлөвлөгөөнд тусгасан		Эвдэрсэн газрын ангилал MNS 5915:2008 Эвдэрсэн газрыннөхөн сэргээлт. Нэр томъёо, тодорхойлолт MNS 5914:2008 Газар шорооныажлын үеийн үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт MNS 5916:2008 Хөрс бохирдуулагчбодисын зөвшөөрөгдөхдээд хэмжээ MNS 5850:2019
Машин механизмын хөдөлгөөн хөрс талхлагдах, бохирдолүүсэх	Орчны авто замд тэмдэгжүүлэх ажил хийх, олон салаа зам гаргахаас сэргийлэх, зогсоол хийх	Төслийн талбай, тээврийн зам дагуу	-	1 000.00	1 сард	
Хог хаягдал, ариун цэврийн байгууламж байгууламжаас бохирдол үүсэх	Барилгын ажлын үед ашиглах хог хаягдлын түр цэг байгуулах	Төслийн талбайд	1 ширхэг	2 000.0	1 сард	
	Химийн бодис хадгалах агуулах орчмын талбайг 2 метрээс багагүй зайд хатуу хучилт хийх	Химийн бодис хадгалах	-	2 000.00	1 сард	

**Орхон аймаг, Баян-Өндөр сум, Баянцагаан багийн нутаг дэвсгэрт орших “Хеви
индастрис технологи жи групп” ХХК-ийн “Хүхрийн хүчлийн үйлдвэр” төслийн байгаль
орчны менежментийн төлөвлөгөө**

2023 он

Химийн бодис хөрсөнд алдагдах		агуулах орчимд				
	Гадна болон дотоод орчны гэрэлтүүлгийг стандартын дагуу хийх, хөрсөнд алдагдахаас сэргийлж битүүмжлэл бүхий саванд хадгалах.		Үйл ажиллагааны зардалд тусгасан			
	Химийн бодис ашиглалтад бэлтгэх, явцад гадна орчинд алдахаас сэргийлж агуулах орчмын гадна талбайг цементлэх	Төслийн талбайд	-	1 000.00		
Зардал					6 000.0	
Ургамлан нөмрөг болон ойн сан						
Олон хүн техникийн нөлөөгөөр тухайн орчны ургамалжлын үндсэн хэв шинж өөрчлөгдөх, төрөл зүйлийн тоо, ургамлын бүрхэц буурах	Ургамлан нөмрөгийн бүрхэц, өөрчлөлтийг судалгааг мэргэжлийн байгууллагаар жил бүр хийлгэж. Өөрчлөлтийг хянаж байх.	Төслийн талбайд	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан	Жилд		
Төслийн талбай доторх модны тоо хэмжээ багасах, хатах, устах	Үйл ажиллагаанд ашиглах талбайг сонгохдоо ойн талбайтай давхцуулахгүй байх, давхацсан тохиолдолд ногоон байгууламж хэлбэрээр үлдээж, зай талбайг зөв зохион байгуулах	Төслийн талбайд	-			Ургамлын тухай хууль Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн ерөнхий шаардлага. MNS 5918:2008

Орхон аймаг, Баян-Өндөр сум, Баянцагаан багийн нутаг дэвсгэрт орших “Хеви индастрис технологи жи групп” ХХК-ийн “Хүхрийн хүчлийн үйлдвэр” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө	2023 он
--	----------------

	Жил бүр талбай доторх ойн хэсэгт мониторинг хийж, хортон шавжаас хамгаалах арга хэмжээ төлөвлөх	Төслийн талбайд	1 500.0	Жилд 1 удаа	
Зардал			1 500.0		
Амьтны аймаг					
Амьтны амьдрах орчин доройтох, хязгаарлагдах	Төсөл байгуулагдах бүсэд амьтдын үүр, нүх сүйтгэгдэхээс сэргийлэх	Төслийн талбайд	-	Төсөл хэрэгжих хугацаанд	
Амьтадамьдрах орчноосоо дайжих	Барилга байгууламж барих үед үүссэн илүүдэл нүх, цооног, овоолсон шороо зэргийг тухай бүрт нь булж хуучин байдалд нь оруулан бөглөх Төслийн талбайн ойр орчмын модонд шувууны үүр барих	Бүс нутагт	1 000.0	Улиралд 1 удаа	
Зардал			1 000.0		
Нийт зардал			1 000.0		

3.2 Хог, хаягдлын менежментийн арга хэмжээ

Хүснэгт 4. Хог хаягдлын менежмент

№	Сөрөг нөлөөллүүд	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт өртөг мян.төг
	Ахуйн хатуу	Хөрсний бохирдол үүсэхээс сэргийлж хогийн сав байршуулах ангилан ялгах хаях ажилчдын байрны ойролцоо болон дотоод орчинд/		ш	200.0	3	600.0

Орхон аймаг, Баян-Өндөр сум, Баянцагаан багийн нутаг дэвсгэрт орших “Хеви индастрис техноложигroup” ХХК-ийн “Хүхрийн хүчлийн үйлдвэр” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө	2023 он
--	----------------

1	болон шингэнхог хаягдал	Хатуу хог хаягдлыг хөрсөнд элдэв шингэн нэвчиж бохирдуулахааргүй, салхинд хийсэж орчныг бохирдуулахааргүй тусгайлсан битүүмжлэл бүхий хогийн цэг байгуулах	Төслийн талбайд	Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөнд тусгасан			
2	Аюултай хог хаягдал, түүний сав баглаа боодол	Хэрэглэсэн химийн бодисын сав баглаа боодлыг цуглуулах стандарт бүхий цэг байгуулан хадгалах	Химийн бодисын агуулах орчимд	ш	8 000.0	1	1 000.0
		Зөвшөөрөл бүхий байгууллагатай хамтран ажиллаж устгуулах арга хэмжээ авах	Химийн болон аюултай бодис бэлтгэн нийлүүлэгч нартай тэдгээрийн сав баглаа боодол, хог хаягдлыг татан авах, зайлуулах гэрээ байгуулж, хамтран ажиллана.				
		Аюултай хог хаягдлын бүртгэл тухай хууль тооллогыг байнга хийж, хянаж байх	Химийн бодисын агуулах	Дотоод төлөвлөлтөөр			
3	Үнсний хаягдал	24x54x4 м хэмээтэй үнсэн сан байгуулах, салхинд хийсч орчны тоосжилт үүсэхээс сэргийлж хамгаалалтын саравч хийх	Үнсэн сан	ш	1 000.0	1	1 000.0
Нийт зардал							2600.0

3.3. Осол, эрсдэл, удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 5. Осол, эрсдэл, удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө

№	Осол эрсдэл	Урьдчилан сэргийлэх хамгаалах аргахэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, Давтамж	Баримлах эрхзүйн баримт бичиг
1	Байгалийн гаралтай осол, эрсдэл	Байгалын гаралтай осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах	Ажилчдад	1 000.00	Сар бүр	"Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх,
		Гал унтраах иж бүрэн хэрэгсэл	Төслийн талбайд	Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан		

2	Биологийн гаралтай осол эрсдэл	Шаардлагатай тохиолдол ажилчдыг амраах	Ажиллах хүч	-	Онц байдал зарласан үед	худалдах журам" - НҮБ-аас 2002 оны 04 сард гаргасан “Аюултай ачаа бараа тээвэрлэх зөвлөмж, зохицуулалтын заавар” - Монгол Улсын замын хөдөлгөөний дүрэм - MNS4978:2000 Аюултай ачаа, ангилал, техникийн шаардлага
3	Технологийн гаралтай осол эрсдэл	Үйл ажиллагааны горим алдагдах, тоног төхөөрөмж эвдрэх, бие эрхтнээ гэмтээх, эрүүл мэндээр хохирох эрсдэл учирч болзошгүй тул эрсдэлээс хамгаалах арга хэмжээг нарийвчилж боловсруулах, эрсдэлийн санг бий болгох Эрсдэлийн сан үүсгэх	Ажилчид	Үйл ажиллагааны зардалд тусгах	Үйл ажиллагааны турш	Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам" - MNS 5029:2011 Химийн хорт бодисын шошго тэмдэглэгээ -MNS6458:2014 Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулахад тавих шаардлага -MNS (ISO)13688:2000
		Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн ханган ажиллуулах	-	3 000.0	2023 он	
		Хөдөлмөр хамгаалал болон болзошгүй осол, аюулаас урьдчилан сэргийлэх, осол аваарын үед авах арга хэмжээний төлөвлөгөө гарган цаг үеийн байдалтай уялдуулан тодотгол хийж, ажиллагсдад сургалт явуулж байх	Төсөвт зардалд тусгасан	Үйл ажиллагааны зардалд тусгасан	Үйл ажиллагааны турш Улирал бүр	
4	Химийн бодисын тээвэрлэлт	Химийн бодисыг тээвэрлэх зориулалтын авто тээврийн хэрэгслийг тоноглох, Химийн бодис тээвэрлэх зам маршрутыг тодорхой болгон, тээвэрлэлт явуулах үйл ажиллагааг хянах, Химийн бодис тээвэрлэх үед химийн бодис алдагдахад авах арга хэмжээг төлөвлөх, хоргүйжүүлэх зааварчилгааг холбогдох хүмүүст өгч ажиллах	Төсөвт зардалд тусгасан			

5	Химийн бодисын хадгалалт, ашиглалт	Агуулахыг салхивчийн систем, тэмдэгжүүлэлтийн стандартын дагуухийж тоноглох.	Төсөвт зардалд тусгасан		Үйл ажиллагааны турш
		ХБ-ын агуулах дотор болон агуулахынгадаад орчны зам талбайг гэрэлтэй болгох, тэмдэгжүүлэх	Химийн бодис хадгалах хэсэгт	3 000.0	2 сард
	Ашигласан ХБ-ын уут савыг түр хадгалах	Тусгай хог хаягдал буюу химийн бодисын сав уутыг хадгалах түр цэгийг кемпийн салхины ноёлох чиглэлийн дорбайгуулан хадгалах, хаяж болох, мэргэжлийн байгууллагаар устгалд оруулах зэргээр ангилна.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэсэгт тусгасан		Үйл ажиллагааны турш
Нийт зардал					7 000.0

3.4. Тухайн жилийн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 6. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Байгаль орчны бүрэлдхүүн	Хяналт шинжилгээнийх үзүүлэлт	Хяналт шинжилгээ явуулах төрөл, хэлбэр	Хяналт шинжилгээ хийх, Сорьцавах цэгийн байршил	Хяналт шинжилгээ явуулах хугацаа, давтамж	Хяналт шинжилгээ явуулах арга, аргачлал	Хяналт шинжилгээ явуулахад шаардлагатай техник, тоног төхөөрөмж	Зарцуулагда хтөсөв /мян.төг/	Үр дүнг нэгтгэх, тайлагнах арга хэлбэр
Агаар орчин	Тоосжилт	Агаарын найрлага, чанар	2	Жилд 2 удаа	Лабораторийн шинжилгээний арга	Агаараас дээж авагч төхөөрөмж	160.0	Лабораторийн шинжилгээний үр дүнд үндэслэн судлаачийн дүгнэлт гаргах
	Агаар дахь хүнд металлуудын агууламжийг тодорхойлох (Pb, Cu, Cd, Cr, Ni, V)					Агаараас дээж авагч төхөөрөмж	50.0	
	Агаарын чанарын (NO ₂ , SO ₂ , CO, TSP, Хүхрийн хүчлийн уур) шинжилгээ хийлгэх					Арчдас авах хөвөн, битүүмжлэлтэй уут	100.0	
Хөрсөн бүрхэвч	Хөрсөн дэх хүнд металлын агууламж	Хөрсний химийн найрлага, элэгдэл эвдрэлийн үзүүлэлтүүд	3	Жилд 2 удаа	Лабораторийн шинжилгээний арга	Хүрз, метр, дээжийн уут	210.0	Лабораторийн шинжилгээний үр дүнд үндэслэн судлаачийн дүгнэлт гаргах
	Ерөнхий хими физикшинж	Ерөнхий шинжилгээ				Хүрз, метр, дээжийн уут	240.0	
Усан орчин	Усан дахь эрдэс бодисууд, химийн найрлага	Усны дэлгэрэнгүй шинжилгээ	2	Жилд 2 удаа		Дээжийн сав	160.0	Лабораторийн шинжилгээний үр дүнд үндэслэн судлаачийн дүгнэлт гаргах

Орхон аймаг, Баян-Өндөр сум, Баянцагаан багийн нутаг дэвсгэрт орших “Хеви индастрис технологи жи групп” ХХК-ийн “Хүхрийн хүчлийн үйлдвэр” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө	2023 он
--	----------------

	Усны хүнд металлын шинжилгээ	Усны бохирдол				Дээжийн сав	80.0	
Ундны ус	Бактериологийн бүрэншинжилгээ /хянгийн тоо болон бактерийн хэмжээ/	Унд ахуйн хэрэглээний ус	2	Жилд 2 удаа	Лабораторийн шинжилгээний арга	Дээжийн сав	90.0	Лабораторийн шинжилгээний үр дүнд үндэслэн судлаачийн дүгнэлт гаргах
Орчны хяналт шинжилгээний нийт зардал: 1 090.0 мян,төг								

3.5. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 7. Удирдлага зохион байгуулалтын ажлын төлөвлөгөө

Арга хэмжээ	Үйл ажиллагаа	Хамрах хүрээ	Зардал мян.төг	Шалгуур үзүүлэлт
Байгаль хамгаалах ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэл өгөх	Үйл ажиллагааны хүрээнд	2023 он	-	Гамшгаас хамгаалах тухайхууль, 2003 (сүүлийн нэмэлтөөрчлөлт 2012 оны 5 сарын17) MNS5078-2001, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ажлын тусгай хувцас- Ерөнхий шаардлага
Ажилчдад байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг хамгаалах талаар сургалтзохион байгуулах	Үйл ажиллагааны хүрээнд	Улирал бүр	800.0	
Болзошгүй осол аюулын үед орон нутгийнэмнэлгийн болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах талаар тохиролцож гэрээ байгуулж ажиллах	Үйл ажиллагааны хүрээнд	Жилд 1 удаа	Талууд тохиролцон о	
Гал түймрийн үед хэрхэн ажиллах талааражиллагсдын дунд сургалт удаа зохион байгуулах	Үйл ажиллагааны хүрээнд	Жилд 1 удаа	500.0	

<i>Орхон аймаг, Баян-Өндөр сум, Баянцагаан багийн нутаг дэвсгэрт орших “Хеви индастрис технологи жи групп” ХХК-ийн “Хүхрийн хүчлийн үйлдвэр” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө</i>	2023 он
--	---------

Ослын үед ажиллах ИТА, ажилчдын үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж , сургалт явуулах	Үйл ажиллагааны хүрээнд	Улирал бүр	1 000.0	“Хөдөлмөрийн аюулгүй байдал, Үйлдвэрлэлийн эрүүл ахуй” MNS ISO 13688 : 2000
Болзошгүй осол, хүний амь насанд аюулчруулж болох нөхцөлүүдээс урьдчилан сэргийлэх эрсдэлийн сан байгуулах	Үйл ажиллагааны хүрээнд	Байнга хяналт тавих	Талууд тохиролцон о	
БО-ны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний нийт зардал : 300.00 мян.төг				

3.6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Төлөвлөгөөт жилд байгаль хамгаалах ажлын хүрээнд хийсэн ажлаа тайлагнах төдийгүй 2023 оны байгаль хамгаалах төлөвлөгөөнд оршин суугчдын зүгээс оруулах санал хүсэлтийг авах, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх зорилгоор энэхүү төлөвлөгөөг боловсруулав.

Хүснэгт 8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр саналавах чиглэл	Зохион байгуулах газар	Зардал, мян.төг
БОАЖЯ	БОМТ-ний тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны БОМТ-ний төсөлтэй хамтатган аймгийн БОАЖЯ хүргүүлнэ	БОМТ-ний хэрэгжилтийн тухай	2023 онд сүүлийн улиралд	БОМТ-ний хэрэгжилтийн тайланг баталгаажуулах.	БОАЖЯ	100.0
Баян-өндөр сум	БОМТ-ний тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, ИТХ-аар оруулж танилцуулах	БОМТ-ний хэрэгжилтийн тухай	2023 онд сүүлийн улиралд	БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнаж олон нийтэд таниулж санал авах	Баян-Өндөр сумын ИНХурлын танхимд	100.0

**Орхон аймаг, Баян-Өндөр сум, Баянцагаан багийн нутаг дэвсгэрт орших “Хеви
индастрис технологи жи групп” ХХК-ийн “Хүхрийн хүчлийн үйлдвэр” төслийн байгаль
орчны менежментийн төлөвлөгөө**

2023 он

Багийн засаг дарга	БОМТ-ний тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж хүргүүлэх	БОМТ-ний хэрэгжилтийн тухай	2023 онд сүүлийн улиралд	БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнаж олон нийтэд таниулж санал авах	Баянцагаан баг	100.0
Нэг жилийн зардал						300.0

3.7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

2023 оны Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний ажлын зардалд нийт 13 990 000 (арван гурван сая есөн зуун ерэн мянга) төгрөгөөр төлөвлөсөн байна.

Хүснэгт 9. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний ажлын зардал

№	Арга хэмжээ	Нийт зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	3000 .00
3	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	2600 .00
5	Осол эрсдлийн менежмент	7 000.00
6	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	2 300.00
7	Тухайн жилийн БОМТ, түүний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь	300.00
8	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	1 090.00
	Нийт зардал	13 990.00

ДҮГНЭЛТ

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг тусгасан болно.

2023 оны Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний ажлын зардалд нийт 13 990 000 (арван гурван сая есөн зуун ерэн мянга) төгрөгөөр төлөвлөсөн бөгөөд бүтээн байгуулалт, үйл ажиллагааны зардлаар томоохон ажлуудыг хийхээр тусгав.